



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН 2025 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2025 он

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

Хяналт-шинжилгээний зорилго, арга зүй

Төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулсан эсэхийг шалгуур үзүүлэлт бүрээр тодорхойлж, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдсэн үнэлгээ, дүгнэлт өгөхөд оршино.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын “Стратеги төлөвлөгөө батлах тухай” 2021 оны 34 дүгээр тушаалаар баталсан стратеги төлөвлөгөөнд “Засгийн газрын шийдвэр боловсруулах, хэрэгжүүлэх, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын харилцан үйл ажиллагааг зохицуулахад туслах, хүний нөөцийн удирдлага, нийтлэг үйлчилгээний удирдлагаар хангах асуудлыг эрхлэн гүйцэтгэнэ” гэсэн ерөнхий чиг үүргийн хүрээнд 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 13 зорилгын 44 зорилт, 184 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх журам”-ыг удирдлага болгон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ хийсэн.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Захиргаа, зохион байгуулалтын газраас нэгтгэж, 95.8 хувиар үнэлэн ирүүлснийг Засгийн газрын “Журам батлах тухай” 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын хоёрдугаар зүйлд заасан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх аргачлалын дагуу хяналт-шинжилгээ хийж, 90.2 хувиар үнэлсэн болно.

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 2.2-т “Төлөвлөгөөг боловсруулахдаа стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан, зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, тухайн жилийн хүрэх түвшин, гүйцэтгэл, үр дүнг тооцсон байна.” гэж заасан.

Харин Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын нэгжүүдийн чиг үүрэгт хамаарах зорилт, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний төлөвлөлт, тайлагналт харилцан адилгүй, тодорхойгүй, нэгдмэл бус байгаа нь стратегийн болон гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг төлөвлөсөн түвшинд хүрсэн эсэхэд бодит дүн шинжилгээ хийх боломжийг бууруулж байна.

Дээрх нөхцөл байдал нь практикт байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт болох тухайн арга хэмжээний хүрсэн түвшин, суурь түвшин, зорилтот түвшнийг хэрхэн тодорхойлох,

тодорхойлох боломжгүй тохиолдолд ямар аргачлалаар илэрхийлэх талаар нарийвчилсан арга зүй, аргачлал тодорхойгүй байгаатай холбоотой.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 2.3-т “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, гүйцэтгэлийг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хэмжиж, үнэлэлт өгөх байдлаар хяналт-шинжилгээг хэрэгжүүлнэ.” гэж, 2.4-т “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээ тус бүрээр дараах аргачлалын дагуу хувиар илэрхийлж дүгнэнэ.” гэж тус тус заасан.

$$\text{Төлөвлөгөөний хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} * 100\%$$

Дээрх аргачлалын дагуу суурь түвшин, зорилтот түвшин, хүрсэн түвшинг тоон утгаар илэрхийлсэн тохиолдолд биелэлтийн дүн гарах зохицуулалттай бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 159 арга хэмжээний суурь түвшин, зорилтот түвшин, хүрсэн түвшинг тоон утгаар илэрхийлээгүй байгаа нь журмын хүрээнд үнэлгээ гаргах боломжгүй нөхцөл байдал үүсгэж байна. Жишээ нь:

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2024 он)	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
	зохицуулалтыг хангахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх					биелэлтийг хангуулан зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.	
1.2.3	Засгийн газрын Үндэсний хороо, зөвлөл, комиссын эрх зүй, эдийн засгийн бодлогын хувилбарыг төлөвлөх, боловсруулах	Үйл ажиллагааны зардлаар	Судалгаа, тооцоо, хувилбарын санал боловсруулалт	Бэлтгэл ажлын шатанд	Судалгаа, тооцоо хийж, хувилбарууд боловсруулж харьцуулалт хийсэн байна.	УИХ-ын “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2024 оны 52 дугаар тогтоолын 8 дахь хэсэгт “хууль тогтоомжид зааснаас бусад яамдын чиг үүрэгтэй давхацсан зөвлөл, хороо, комисс, төвүүдийг татан буулгаж, чиг үүргийг холбогдох яамдад шилжүүлэх” чиглэл өгсөнтэй холбогдуулан Үндэсний хороо, зөвлөлийн чиг үүргийн давхардалд дүн шинжилгээ хийж, зарим хороо, зөвлөлийг татан буулгах, нэгтгэх саналыг бэлтгэж, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, дэд дарга, газрын дарга нарт өгч Ерөнхий сайдад танилцуулсан. Сангийн яамнаас 11 хороо, зөвлөлийг татан буулгах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан ирүүлсэн бөгөөд тухайн ирүүлсэн материалд үндэслэн дахин судалгаа хийж, Засгийн газрын 2025.07.09-ний өдрийн 22 дугаар тогтоолоор 29 үндэсний хороо, зөвлөлийг татан буулгасан.	100%
1.2.4	Засгийн газрын Үндэсний хороо, зөвлөл, комиссын үйл ажиллагааны үр дүнг олон нийтэд нээлттэй хүргэх	Үйл ажиллагааны зардлаар	Үнэн зөв, хуулийн хугацаанд мэдээлсэн эсэх	Тодорхой хэмжээнд мэдээлдэг.	Үнэн зөв, хуулийн хугацаанд мэдээлсэн байна.	Хороо, зөвлөл, комиссын ажлын албаны дарга нарт үйл ажиллагааны үр дүнг олон нийтэд тухай бүр шуурхай хүргэх чиглэлийг өгч ажиллаж байна. Үндэсний хороо, зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг салбарын яам, агентлагийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж байна.	100%
Зорилт 1.3	Хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд хэрэгжих томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүй, эдийн засгийн бодлогын хувилбарыг төлөвлөх, боловсруулах, гүйцэтгэл, зохион байгуулалтын уялдааг хангах, хяналт тавих.	Үйл ажиллагааны зардлаар	Томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх эрх зүй, эдийн засгийн боломж	Тодорхой хэмжээнд бүрдсэн.	Хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд хэрэгжих томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжих эрх зүй, эдийн засгийн боломж бүрэн бүрдсэн байх	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 14 мега төсөл, бусад хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг салбарын яамд, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна. “Хөгжлийн төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай”	93%

4

Иймд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2-т заасны дагуу бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийг хувийг тодорхойлохдоо хэрэгжүүлсэн үйл ажиллагаанаас шалтгаалан 90, 70, 50, 30, 0 гэсэн хувиар үнэлдэг байсан аргачлалыг жишиг болгосон.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 184 арга хэмжээний хэрэгжилтийг тус бүрийн гүйцэтгэлээр дараах байдлаар үнэлэв.

№	Төлөвлөлтийн хэсэг	Зорилт	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь
Зорилт 1.1	Төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, бодлого зохицуулалтыг хангахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг зохих журмын дагуу хянаж, Хэрэг эрхлэх газрын саналыг бэлтгэж, удирдлагыг зөвлөгөө, мэдээллээр хангах	1	25	93.6%
Зорилт 1.2	Үндэсний хороо, зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэр, удирдлага зохицуулалтыг хангахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг зохих журмын дагуу хянаж, ЗГХЭГ-ын саналыг бэлтгэж, удирдлагыг зөвлөгөө, мэдээллээр хангах	1	4	42.5%
Зорилт 1.3	Хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд хэрэгжих томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүй, эдийн засгийн бодлогын хувилбарыг төлөвлөх, боловсруулах, гүйцэтгэл, зохион байгуулалтын уялдааг хангах, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэгжилтийн тайланг нэгтгэн зохион байгуулах, төсөл, хөтөлбөрийн мэдээлэлтэй холбоотой бүх талын үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх	1	3	46.6%
Зорилт 1.4	Салбарын бодлого зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээ авах, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах	1	3	100%
Зорилт 2.1	Хууль тогтоомжийн болон Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хянан зөвшөөрөл өгөх, ЗГХЭГ-ын саналыг боловсруулах, Засгийн газрын шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн гаргахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	1	2	100%
Зорилт 2.2	Хууль зүй, дотоод хэргийн салбар, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны бодлого төлөвлөлт, удирдлага, зохицуулалтыг хангахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг зохих журмын дагуу боловсруулан бэлтгэх	1	1	100%
Зорилт 2.3	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах чиглэлээр дэмжлэг үзүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хууль тогтоомжийн төсөл, Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруула	1	3	100%

Зорилт 2.4	Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэхэд эрх зүйн зөвлөгөө болон бусад дэмжлэг үзүүлэх	1	5	100%
Зорилт 2.5	Удирдлагын шийдвэрийн дагуу Засгийн газар, ЗГХЭГ-ыг шүүх, прокурорын байгууллагад төлөөлөх	1	3	100%
Зорилт 3.1	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, нутгийн захиргааны байгууллагын зохион байгуулалт, удирдлагыг боловсронгуй болгоход чиглэсэн хууль тогтоомж, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	1	2	100%
Зорилт 3.2	Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;	1	3	90.0%
Зорилт 3.3	Аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах, Засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, орон нутгийн бие даасан байдлыг хангахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	1	5	94.0%
Зорилт 3.4	Бүс, орон нутгийн хөгжлийг хангах хүрээнд бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	1	7	91.4%
Зорилт 4.1	Захиргааны удирдлагын манлайллыг хангах, ЗГХЭГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, байгууллагын дотоод үйл ажиллагаанд зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх	1	6	70.0%
Зорилт 4.2	Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, удирдлагыг мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах ажлыг зохион байгуулах	1	9	74.4%
Зорилт 4.3	ЗГХЭГ-ын ижил төрлийн болон холбогдох бусад байгууллагатай харилцах, уулзалт зохион байгуулах, арга хэмжээг баримтжуулах	1	3	90.0%
Зорилт 4.4	Засгийн газрын хуралдааны бэлтгэлийг хангах, зохион байгуулах, шийдвэрийг албажуулах, Засгийн газрын хуралдааны явцыг баримтжуулах, танхимын үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх	1	6	83.3%
Зорилт 4.5	Төрийн болон албаны нууцын тухай, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах	1	6	83.3%
Зорилт 4.6	Албан хэрэг хөтлөлт, архивын ажлыг эрхлэн гүйцэтгэх, тамга, тэмдгийн бүртгэл хөтлөх, төрийн байгууллага, албан тушаалтанд тамга хийлгэх зөвшөөрөл олгох ажлыг хариуцах, хяналт тавих	1	9	87.7 %
Зорилт 4.7	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг нэгтгэн тодорхойлох	1	6	100%

Зорилт 5.1	Засгийн газар, ЗГХЭГ-ын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх замаар дижитал шилжилтийг хийх, Ерөнхий сайд, ЗГХЭГ-ын удирдлагад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	1	4	87.5%
Зорилт 5.2	Засгийн газар, ЗГХЭГ-ын цахим систем, сүлжээ, компьютер, техник тоног төхөөрөмжийн байнгын ажиллагаа, Засгийн газрын хуралдааны танхим, цахим хурлын бэлэн байдлыг хангах Байгууллагын дотоод удирдлагын систем (www.digital.gov.mn)-ийн хэвийн ажиллагааг хангах, системийг удирдан зохион байгуулах	1	7	100%
Зорилт 5.3	Мэдээллийн ил тод байдал, вэб сайтын байнгын ажиллагааг хангаж, иргэд олон нийтэд нээлттэй мэдээ мэдээлэл хүргэх	1	2	100%
Зорилт 6.1	Төрийн албаны хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, эрх зүйн орчныг боловсронгуй болгох	1	2	100%
Зорилт 6.2	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн мэдээллийн системийг хөгжүүлж үе шаттай нэвтрүүлэх	1	2	40.0%
Зорилт 6.3	Төрийн албаны сургалтын орчин нөхцөлийг сайжруулж, төрийн албан хаагчийг сургаж, хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно.	1	2	65.0%
Зорилт 6.4	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх	1	2	100%
Зорилт 6.5	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах	1	1	100%
Зорилт 7.1	ТЕЗ-дын төсвийн төсөл, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, захиран зарцуулах, тайлагнах, хөндлөнгийн аудит хийлгэх, шилэн данс хөтлөх ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, зохицуулах	1	8	90.6%
Зорилт 7.2	ЗГХЭГ-ын эд хөрөнгийг хариуцан, дотоод үйлчилгээг эрхлэх	1	4	87.5%
Зорилт 8.1	Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, УИХ-ын дэд дарга, Шадар сайд нарын үйл ажиллагааны ёслолын арга хэмжээг холбогдох журмын дагуу эрхлэн явуулах	1	4	100%
Зорилт 8.2	Төрийн арга хэмжээний ёслолын үйл ажиллагааг зохион байгуулах	1	4	100%
Зорилт 9.1	Засгийн газрын бодлого, Засгийн газар, Ерөнхий сайдын үйл ажиллагааны талаар олон нийтийг нээлттэй, шуурхай мэдээллээр хангах, хэвлэл мэдээлэлтэй харилцах, Ерөнхий сайдын хэлэх үгийн төслийг бэлтгэх	1	11	97.2%

Зорилт 9.2	Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны талаар иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлүүлэх, олон нийттэй харилцах	1	5	90.0%
Зорилт 10.1	Ерөнхий сайдад бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь чиглэсэн бодлогын зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, өдөр тутмын үйлчилгээгээр хангах	1	2	100%
Зорилт 11.1	Шадар сайдад бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь чиглэсэн бодлогын зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, өдөр тутмын үйлчилгээгээр хангах	1	4	100%
Зорилт 12.1	Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдох бусад зорилт, арга хэмжээ	1	2	100%
Зорилт 12.2	Архивын тухай хууль, дотоод журмын дагуу хийсэн ажлын болон хүлээн авсан мэдээ, тайлан, баримтуудыг ЗГХЭГ-ын архивт хугацаанд нь бүрэн шилжүүлэх	1	1	100%
Зорилт 12.3	Холбогдох хуульд заасан журмын дагуу ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зохих байгууллагад мэдүүлэх	1	1	100%
Зорилт 12.4	"Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, тайлагнах	1	1	100%
Зорилт 13.1	"Төрийн албан хаагчдын тоо бүртгэл, статистик мэдээллийг албан тушаалын ангилал, зэрэглэл, төрөл тус бүрээр хүйсээр гаргаж, хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтад ашиглах	1	1	30.0%
Зорилт 13.2	Төрийн албаны тухай хууль болон холбогдох дүрэм журам, бодлого төлөвлөлтөд жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлэх, ялгаварлан гадуурхалтад үр дүнтэй хариу үйлдэл үзүүлэх чиглэлээр шинэчилж, хэрэгжилтийг хангах	1	1	80.0%
Зорилт 13.3	Төрийн албаны удирдах албан тушаалтны гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтэд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалттай тэмцэх талаар үзүүлэлтийг тусгах	1	1	70.0%
Зорилт 13.4	Төрийн байгууллагын дэргэдэх болон үндэсний хэмжээний хороо, зөвлөл, комисс зэрэг зөвлөлдөх буюу хамтын удирдлагын байгууллагын бүрэлдэхүүний хүйсийн харьцааг тогтоох, сонгон шалгаруулах, томилох нийтлэг зөвлөмж гаргаж, хэрэгжилтийг хангах	1	1	80.0%
Гүйцэтгэлийн үнэлгээ		44	184	90.2%

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд туссан 44 зорилтод хамаарах 184 арга хэмжээний хүрсэн түвшний үнэлгээний дэлгэрэнгүйг хавсаргасан болно.

Зохион байгуулалтын нэгжүүдийн жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ хийсэн дүн

№	Газар	Зорилт	Арга хэмжээ	Нэгжийн өөрийн үнэлгээ (хувь)	ХШҮнэлгээ (хувь)	Зөрүү
1	Хууль, эрх зүйн газар	9	18	99.7	95.6	4.1
2	Салбарын бодлого, зохицуулалтын газар	5	33	97.8	92.6	5.2
3	Захиргаа, зохион байгуулалтын газар	8	62	94.53	92.63	1.9
4	Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газар	8	31	99.31	97.81	1.5
5	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	5	24	91.41	91.41	0
6	Засгийн газрын хүний нөөцийн газар	7	36	91.93	91.21	0.72
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	7	31	99.27	91.47	7.8
8	Төрийн ёслолын газар	3	13	100	94.42	5.58
9	Төсөл, хөтөлбөр, гадаад харилцаа, хамтын ажиллагааны газар	10	25	98.83	91.3	7.5
Нийт		62	273	96.98	93.16	3.82
10	Ерөнхий сайдын ажлын алба	1	2	100	100	-
11	Шадар сайдын ажлын алба	1	4	100	100	-
12	Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах газар	2	16	95	95	-
Нийт		66	295	97.3	94.4	

Дүгнэлт

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар 95.8 хувиар үнэлэн ирүүлснийг тус нэгжээс хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж 90.2 хувьтай буюу “Бүрэн хангалттай” гэж үнэлэв.

Тухайлбал арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, гарч эхэлсэн 85 буюу

түүнээс дээш хувийн хэрэгжилттэй 144 арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах 70-85 хүртэлх хувийн хэрэгжилттэй 20 арга хэмжээ, удирдлага, зохион байгуулалт хангалтгүй 70 хүртэл хувийн хэрэгжилттэй 20 арга хэмжээ байна.

2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зарим зорилт, арга хэмжээний хэрэгжилт “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмын 2.4-т заасан төлөвлөгөөг хэрэгжүүлснээр бий болох үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй, тоон ба чанарын утгаар илэрхийлэгдэх, хэмжигдэхүйц, үр дүнг харуулсан байх нөхцөлийг бүрдүүлээгүй байна.

Улмаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд туссан тоон болон чанарын утгаар илэрхийлэгдээгүй хүрсэн түвшинг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх журамд заасан аргачлалаар үнэлэх боломжгүй нөхцөлийг үүсгэж байна.

Иймд зохион байгуулалтын нэгж газруудын холбогдох зарим арга хэмжээний үнэлгээг бууруулж тооцсон болно. Жишээ нь, шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй, зорилтот түвшинд хүрсэн эсэх нь тодорхойгүй, төлөвлөлт, тайлагнал дутуу, мэдээлэл хангалтгүй, зорилт, арга хэмжээ хоорондоо уялдаагүй, оновчтой бус, ойлгомжгүй, байна.

3. Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд гарсан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилтын биелэлтийг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг нэгтгэн оновчтой тодорхойлж төлөвлөлтийг сайжруулах, мөн арга хэмжээний биелэлтийг тодорхой өөрчлөлт үр дүн гарсан эсэхийг хэмжигдэхүйцээр энгийн ойлгомжтой цаг хугацаатай, суурь түвшинг хүрсэн түвшинтэй харьцуулан өөрчлөлт гарсан эсэхийг товч тайлагнахад анхаарах шаардлагатай байна.
- Нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт, зөвлөмжөөр өгсөн үүргийг сайжруулах, зорилтот түвшинд хүрээгүй ажлуудыг дараа оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхэд анхааран ажиллах.
- Цаашид байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд арга хэмжээг уялдуулж шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг оновчтой тодорхойлон тоон болон чанарын үзүүлэлт ашиглан хэмжигдэхүйц байхаар төлөвлөхөд анхаарч ажиллах шаардлагатай байна.

4. Стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдсан арга хэмжээ бус зохион байгуулалтын нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан албан хаагчийн чиг үүрэгт хамаарах арга хэмжээ бүрийг давхардуулан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан нь төлөвлөлт алдаатай оновчгүй байна.

5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхэд нэгжүүдийн болон төрийн байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын чиг үүрэгт хамааралгүй буюу салбаруудын хариуцан хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий шийдвэрийг

даалган баталж байгаа нь салбарын чиг үүргийг тодорхойгүй, ойлгомжгүй болгож тухайн ажил эзэнгүйдэх, хэрэгжих боломжгүй нөхцөлд хүргэж байгаагаас гадна бусад байгууллагын хийсэн ажлыг давхар тайлагнах тохиолдол гарч байна.

6. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралт болох Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр, Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгүүлэхээр ирүүлээгүй байна;

7. Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шилэн дансны хөтлөлт, нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийн талаарх тайлагналтын хугацаа болоогүй бөгөөд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тухай бүр Засгийн газрын хяналт-шилжилгээ, үнэлгээний цахим системээр дамжуулан журмын цаглаварт заасан хугацаанд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт тайлагнах.

Зөвлөмж

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээний үр дүнг үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Байгууллагын төлөвлөгөөний биелэлтэд туссан үр дүнгийн талаарх нотлох баримт, тоон болон чанарын үзүүлэлтийг заавал хавсаргах, агуулгыг бодит үр дүнд тулгуурлан боловсруулж, тайлагнал, нотлох баримтын чанарыг дээшлүүлэх;

2. Арга хэмжээ бүрд хариуцах нэгж, албан тушаалтны хариуцлагыг тодорхой болгож, хэрэгжилтийн явцад хяналт тавих, нэгжүүдийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр дотоод зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмын 2.3-т заасны дагуу хуулиар олгосон чиг үүргийн дагуу мандатын шинжилгээ хийсний үндсэн дээр арга хэмжээг тодорхойлох;

4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах зорилт, арга хэмжээг SMART шалгуур (тодорхой, хэмжигдэхүйц, хүрэхүйц, бодитой, хугацаатай)-т нийцүүлэн боловсруулж давхардсан, хоорондоо уялдаа сул арга хэмжээг нэгтгэх, оновчтой болгох замаар төлөвлөлтийг сайжруулах;

5. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралт болох “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр”, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-т үндэслэж тодорхой арга хэмжээ төлөвлөх;

6. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тавигдах нийтлэг шаардлагуудыг баримтлан, байгууллага, албан хаагчдыг чадавхжуулахад анхаарч, гүйцэтгэл нь зорилтод түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхой тайлбарлах, цаашид үргэлжлүүлэх шаардлагатай арга хэмжээг дараа жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой тусгах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх;

7. Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 217 дугаар тогтоолоор батлагдсан Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмын дагуу стратеги төлөвлөгөөнд тусгасан зорилтын хүрээнд хүлээгдэж байгаа өөрчлөлтийг илэрхийлсэн тодорхой зорилт, арга хэмжээг агуулсан, зорилт, арга хэмжээ нь хоорондоо уялдсан байх нөхцөлийг бүрдүүлэх;

8. Хэрэгжилтийн явцад улирал тутам дотоод хяналт-шинжилгээ хийж, эрсдэл илэрсэн арга хэмжээнд тухай бүр залруулах арга хэмжээ авах тогтолцоог төлөвшүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг удирдлагын шийдвэр гаргалтад ашиглах, дүгнэлт, зөвлөмжийг дараа оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад заавал харгалзан үзэх;

9. Өмнөх жилүүдийн гүйцэтгэлийн дата дээр суурилж, хэрэгжилт саарах магадлалтай арга хэмжээг автоматаар илрүүлэх, хугацаа хоцрох, биелэлт хангалтгүй байх эрсдэлийг урьдчилан таамаглах, анхааруулах, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон үр дүнгийн зөрүүг илрүүлэх, дүн шинжилгээг автоматжуулах, давхардал, зөрчил байгаа эсэхийг шалгах зэргээр гүйцэтгэлийн эрсдэлийг урьдчилан илрүүлэх, чанар, бодит байдлыг сайжруулах, хяналт-шилжилгээний субъектив байдлыг бууруулах асуудлыг судалж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн цахим мэдээлэлд тулгуурлан хиймэл оюун ухаан ашиглах үе шаттай бодлого, замын зураглал (AI roadmap) боловсруулж, туршилтын хүрээнд нэвтрүүлэх.

10. Хиймэл оюун ухаанд суурилсан удирдлагын хяналтын самбар (AI dashboard) нэвтрүүлж, гүйцэтгэлийн чиг хандлага, биелэлт, эрсдэлийг бодит цагийн горимд харуулах, ямар зорилт, арга хэмжээнд удирдлагын анхаарал, нөөц илүү шаардлагатайг автоматаар санал болгодог шийдлийг эрэлхийлэх замаар удирдлагын шийдвэр гаргалтад хиймэл оюуныг ашиглах;

11. Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журмын 2.1-т заасны дагуу төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг хариуцсан чиг үүрэг бүхий нэгжид ирүүлж хяналт-шинжилгээ хийлгэх;

12. Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.” гэж, 54 дүгээр зүйлийн 54.1-т “Төсвийн шууд захирагч тухайн жилийн Төсвийн тухай хуульд заасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг зохион байгуулах зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан баталж, ... хэрэгжүүлнэ.” гэж, 55 дугаар зүйлийн 55.1-т “Төрийн жинхэнэ албан хаагч хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан.

Иймд төсвийн ерөнхийлөн болон төсвийн шууд захирагч, төрийн жинхэнэ албан хаагчийн баталж, хэрэгжүүлэх төлөвлөгөөний гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох арга зүй, аргачлалыг нарийвчлан тодорхой болгож, төрийн бүх шатны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний чиг үүрэг бүхий албан хаагчдыг мэргэшүүлэх, тогтвортой ажиллуулах, хууль эрх зүйн орчныг

шинэчлэх, Хяналт-шинжилгээ, үнэлгээний тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР